



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 955


Улаанбаатар хот

Ажлын хэсэг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.8, 8.1.9, 31 дүгээр зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын хамтарсан 491/A472 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, "ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 04 сарын 2-дөдрийн
155 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Э.Оюунсүрэн, Эрүүл мэнд, спортын яамны /ЭМСЯ/
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын
дарга

Нарийн бичгийн дарга: С.Отгонсүх, ЭМСЯ-ны Эрүүл мэндийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн дээд
мэргэжилтний хөгжлийн бодлогын хэрэгжилтийн
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Ч.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга

Г.Баясгалан, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дарга

Б.Ганбат, Нийслэлийн эрүүл мэндийн газрын орлогч
дарга

Ц.Лхагва, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн
дарга

С.Мөнхбаярлах, Анагаахын шинжлэх ухааны үндэсний
их сургуулийн Анагаах ухааны их сургуулийн захирал

Ц.Даваахүү, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
мэргэжилтэн

Б.Мөнхцэцэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
мэргэжилтэн

Ц.Тунгалаг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
мэргэжилтэн

Я.Бадамсүрэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
мэргэжилтэн

А.Болд, Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4
төслийн эмнэлгийн тусламжийн асуудал хариуцсан
зохицуулагч

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Үндэслэл:

Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын хамтарсан 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Журам батлах шинэчлэн батлах тухай” 491/А/472 тушаалын зарим заалтууд тодорхой тусгагдаагүй, гүйцэтгэлийн явцад хүндрэл гардаг, ажлын ачааллын тэнцвэрт байдал алдагддаг, бусад холбогдох журмын заалттай зөрчилддөг зэрэг хүндрэл гардагаас уг журмыг шинэчлэн өөрчлөх шаардлага тулгараад байна.

Тус журмын 2.6-д заасан заалт Эрүүл мэндийн сайдын 2014 оны 5-р сарын 16-ны өдрийн 166 дугаар тушаалаар зохицуулагдсан байдаг. Ажиллаж байгаа хугацааг үндсэн мэргэжлийн сургалтын эхний 2 жилийн хугацаанд оруулсан.

Мөн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг хэн боловсруулах, хөтөлбөрийг үнэлэх заалт заагдаагүй нь хөтөлбөрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж тухайн ажлыг гүйцэтгүүлэхэд хүндрэлтэй, удаашралтай байна.

Төрөлжсөн мэргэшлийн сургалтыг жилд 1 удаа үндсэн мэргэшлийн сургалттай зэрэг эхэлж байгаа нь сургалт эрхлэгч байгууллагын багтаамж, ачаалал ихсэх, эмнэлгийн халдвар хамгааллын дэглэм алдагдах, сургалтын чанарт сөргөөр нөлөөлдөг. Захиалагч байгууллага нь /ялангуяа орон нутгаас/ жилд 1 удаа мэргэжилтнүүдээ олноор нь зэрэг сургалтанд явуулахад хүний нөөцийн хомсдолд ордог, хэрэгцээт сургалтандаа хамрагдаж чаддаггүй, ирсэн эмч нь сургалтын дундаас хүний нөөцийн хомсдолоос болж орон нутаг руугаа буцах тохиолдол гарсаар байна.

Багц цагийн сургалтын багцыг журамд заасан /12 цагийн лекц, 24 цагийн дадлага тус бүр 1 багц цаг гэж/ цагаар олгож байгаа нь эрүүл мэндийн салбарт ач холбогдол багатай хувь хүний сонирхолд нийцсэн бизнесийн үйл ажиллагааг дэлгэрүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Эмнэлгийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтыг жилд 2 удаа гэж заасан нь мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байна. / Мэргэжил дээшлүүлэх сургалт 1 сараас 5 сар хүртэл үргэлжилж байгаа тул 1-3 сар хүртэлх хугацааны сургалт жилд 3-4 удаа явагдах боломжтой.

Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохицуулдаг журмуудыг нэгтгэх (одоогийн журмууд хоорондоо уялдаагүй байна. 491/А/472,166,157)

Эрүүл мэнд спортын яамны харъяа Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний эрх, үүргийг тодорхой болгох, ажлын гүйцэтгэлийн урамшууллын системийг бий болгох зэрэг бэрхшээлүүдийг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.

Зорилго:

Төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам, эмнэлгийн мэргэжилтэнд зэрэг олгох, хүчингүй болгох журмыг боловсронгуй болгох

Зорилт:

- Эмнэлгийн мэргэжилтэний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журмыг шинэчлэн боловсруулах, суралцах үйл ажиллагаатай холбоотой гарсан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх
- Эмнэлгийн мэргэжилтэнд зэрэг олгох, хүчингүй болгох журмыг боловсронгуй болгох
- Эмнэлгийн мэргэжилтэний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтын дэвтрийн үлгэрчилсэн загвар, төгсөгчдөд олгох үнэмлэх, гэрчилгээний загвар болон бусад холбогдох бичиг баримт зэргийг шинэчлэх сайжруулах

Хугацаа:

2015 оны 04 дүгээр сард

Үр дүн:

Дээрх журмуудыг шинэчлэн боловсруулснаар эмнэлгийн мэргэжилтэний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, төгсөлтийн дараах сургалтад суралцах үйл ажиллагаатай холбоотой гарсан хүндрэл, бэрхшээлтэй асуудлууд шийдвэрлэгдэнэ. Эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүд мэргэших болон тасралтгүй сургалтын тохиромжтой хувилбаруудыг сонгох нөхцөлөөр хангагдана.